



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 дугаар 01 өдөр

Дугаар А/108

Жаргалант

**Тамга, тэмдэг түших, хэвлэмэл хуудас хариуцах
эрх бүхий албан тушаалтан томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 226 дугаар тогтоолоор баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх хэрэглэх журам”-ын 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын тамга, Засаг даргын Тамгын газрын даргын тэмдэг түших ажилтнаар Засаг даргын Тамгын газрын даргыг томилсугай.

2.Баян-Өлзийт, Ангирт, Онон, Жаргалант багийн Засаг даргын тамгыг түших ажилтнаар багийн Засаг дарга Х.Амарбаясгалан, А.Уранчимэг, Э.Бат-Орших, Г.Оюунчимэг нарыг томилсугай.

3.Баян-Өлзийт, Ангирт, Онон, Жаргалант багийн Засаг даргын хэвлэмэл хуудсыг багийн Засаг дарга Х.Амарбаясгалан, А.Уранчимэг, Э.Бат-Орших, Г.Оюунчимэг нарт хариуцуулсугай.

4.Албан ёсны, бүрэн бүрдэлтэй баримт бичгүүдийг тамга, тэмдгээр баталгаажуулан, баримт бичгийн стандартад заасан шаардлагын дагуу баримт бичгийг баталгаажуулж байхыг Засаг даргын Тамгын газрын дарга, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж тайланг хагас бүтэн жилээр гаргаж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6.Уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232501757